



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 12 он 04  
сарын 25 өдөр

Дугаар 37-1/66

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

Тогтоолын төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Хөтөлийн “Цемент шохой” компанийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах тухай Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолын холбогдох заалтыг хүчингүй болгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224001592



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20<sup>20</sup> он <sup>04</sup> дугаар  
сарын <sup>15</sup>-ны өдөр

Дугаар ХЭТ/821

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Хөтөлийн “Цемент шохой” компанийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах тухай Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолын холбогдох заалтыг хүчингүй болгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн тул холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт<sup>2</sup> хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



  
Ц.НЯМДОРЖ


000225004514

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлд:

“I.ХЭЛЭЛЦСЭН нь: “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.04.12 № 1/2083  
танай 2022.04.07-ны № ХХ/754-Т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

  
Х.НЯМБААТАР

151601687  
А5 Файл.2022





**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1 Засгийн газрын II байр,  
Утас/факс (976-51) 26-74-68 <http://www.mof.gov.mn>

2022.04.13 \ 01/2250

танаг 2022.04.07 ны \хэт/753 -Т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ  
ТАНАА**

Хөтөлийн “Цемент шохой” компанийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах заалтыг хүчингүй болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

**9761000593**



**“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад Улсын Их Хурал “төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй” гэж заасан бөгөөд мөн хуулийн 62 дугаар зүйлд “хувьчлан авагч эд хөрөнгийн үнэ, хууль, гэрээнд заасан бусад төлбөрийг гэрээний хугацаанд төлөөгүй буюу төлбөрийг хууль бусаар хийсэн;”, “хувьчлан авагчид нь хуульд зааснаас илүү хөнгөлөлт, давуу эрх олгосон;” үндэслэл байвал хувьчиллыг хууль бус гэж үзэж хүчингүй болгоно” гэж заасан.

Түүнчлэн өнөөгийн дэлхий дахинд үүсээд байгаа олон нийтийг хамарсан цар тахал, олон улсын хямралт нөхцөл байдлаас хамаарч хилээр бараа, бүтээгдэхүүн тээвэрлэх, нэвтрүүлэх боломж бололцоогүй болох, дотоодод бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх, хомсдол үүсэх зэрэг сөрөг үр дагаврууд бий болдог байх тул барилга, зам, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарт өргөнөөр хэрэглэгддэг, гол нэр төрлийн материал болох цементийн үйлдвэрлэлийг төрийн оролцоо, дэмжлэгээр хангах зайлшгүй шаардлагатай байна.

Ус, дулаан хангамж, инженерийн шугам сүлжээтэй, төвийн бүсийн цахилгаан, эрчим хүч, төмөр зам, авто замын нэгдсэн сүлжээнд холбогдсон, дэд бүтэц сайтай, сүүлийн үеийн дэвшилтэд техник технологи бүхий уг үйлдвэрээр дамжуулан бүтээгдэхүүний чанарыг сайжруулах болон цементийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангуулах, үнийн хөөрөгдлийг хязгаарлах, хянах боломж бүрдэж, төвийн болон зүүн бүсийн аймгууд Улаанбаатар хотоос цемент худалдан авч байгаа хөдөлгөөний ачааллыг бууруулах, хөдөө, орон нутгийн хэрэглээг шууд хангах системд шилжих боломжтой болно.

Улсын чанартай томоохон бүтээн байгуулалт, тэр дундаа стратегийн ач холбогдолтой авто зам, төмөр замын барилга байгууламж, суурь бүтцийн угсралтын ажил хийгдэж, нэгдсэн замын сүлжээ бий болж байгаатай уялдуулан Хөтөлийн “Цемент шохой” үйлдвэрээс аймгийн төвүүдийн цементийн тээвмүүдэд хямд өртөгтэй клинкер нийлүүлэх, тэдгээрийн бүтээгдэхүүний өртгийг хямдруулах боломжтой болно.

Ингэснээр орон нутгийн цементийн хэрэглээний бүс тус бүрд 100.0 мянган тонн цемент тээрэмдэх хүчин чадал бүхий тээрмүүд суурилуулан орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх, аймаг, сумын төвийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох боломжийг бүрдүүлнэ.

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тогтоол, “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 330 дугаар тогтоол, мөн Төрийн өмчийн хорооны 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 608 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчилж, Төрийн өмчийн хорооны 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 617 дугаар тогтоолоор “Бейзмент” ХХК-д хувьцааны өмчлөгчийн эрхийг олгосон байна.

“Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит компанийн хувьчлалыг хууль зөрчсөн гэж үзэж “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит компанийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 124 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 108 дугаар тогтоолоор хүчингүй болгоод байна.

Концессын тухай хуулийн 8.1.2-т “концессын гэрээний хугацаанд концессын зүйлийг хувьчлах шийдвэр гаргах”-ыг хориглохоор заасан байхад хувьчилсан нь буруу байх тул “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит компанийг хувьчлах жагсаалтаас хасаж, төр хөрөнгөө буцааж авах нь зүйтэй байна.

### **Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн “4.17.Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах” гэсэн заалтыг хасахаар боловсруулна.

### **Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар дараахь нийгэм, эдийн засгийн эерэг үр дагавар бий болно гэж үзэж байна:

Авлигатай тэмцэх газраас 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 32 дугаар “Мөрдөгчийн мэдэгдэл”-д Хөтөлийн Цемент Шохой ТӨХК /хуучнаар/-ийн хувьчлалыг хэрэгжүүлэхдээ Бейзмент ХХК-д давуу байдал бий болгон төрд их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдэгдсэн болохыг дурдсан.

Түүнчлэн, барилгын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох цементийн чанарыг сайжруулах, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангуулах, үнийн хөөрөгдлийг хязгаарлах, хянах боломж бүрдэнэ.

Төвийн болон зүүн бүсийн аймгууд Улаанбаатар хотоос цемент худалдан авч байгаа хөдөлгөөний ачааллыг бууруулах, хөдөө, орон нутгийн хэрэглээг шууд хангах системд шилжих боломжтой болно.

Улсын чанартай томоохон бүтээн байгуулалт, тэр дундаа стратегийн ач холбогдолтой авто зам, төмөр замын бүтээн байгуулалтын ажлын өртөг, зардлыг бууруулах боломжтой болно.

Хөдөө, орон нутгийн цементийн хэрэглээний бүс тус бүрд 100.0 мянган тонн цемент тээрэмдэх хүчин чадал бүхий тээрмүүд суурилуулан орон нутаг үйлдвэрлэл хөгжүүлэх, аймаг, сумын төвийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох боломжийг бүрдүүлнэ.

Цемент шохой төрийн өмчит хувьцаат компаниас чанарын баталгаатай чулуунцар нийлүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэлд мэргэжлийн хяналт тавьж, цементийн чанар баталгаатай болох, орон нутагт баригдаж байгаа зам, барилгын чанар, цементийн эрэлт нийлүүлэлтийг хянах төрийн оролцоо бүхий олон улсын жишигт нийцсэн тогтолцоо бий болгох боломж бүрдэнэ.

Төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажил хийгдэж, нэгдсэн сүлжээ бий болж байгаатай уялдуулан аймгийн төвүүдийн тээрмүүдэд клинкер татах боломж бий болж, бүтээгдэхүүний өртөг хямдрах боломжтой болно.

**Дөрөв.Тогтоолын төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдаж буй байдал, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай санал**

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай тус тус нийцсэн болно.



## ТАНИЛЦУУЛГА

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн 4.17-д “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах” гэж, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолоор баталсан “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт”-ын 15-д “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах гэж тус тус заасны дагуу “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийг хувьчилсан.

“Хөтөлийн цемент шохой” үйлдвэр нь 1983 онд байгуулагдсан бөгөөд Засгийн газрын 2001 оны 35 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2001 оны 442 дугаар тогтоолоор хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн бөгөөд хувьчлагдах үед шохойн чулууны 2 орд газартай, үйлдвэрлэл тогтворжиж, бүтээгдэхүүний чанар баталгаажсан, үйлдвэрлэл нь хуурай аргын техник технологид шилжсэн, дэд бүтэц сайтай, мэргэшсэн, туршлагатай ажиллах хүчний нөөцтэй сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи бүхий үйлдвэр байсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлд “хувьчлан авагч хөрөнгийн үнэ, хууль, гэрээнд заасан бусад төлбөрийг гэрээний хугацаанд төлөөгүй буюу төлбөрийг хууль бусаар хийсэн;”, “хувьчлан авагчид нь хуульд зааснаас илүү хөнгөлөлт, давуу эрх олгосон;”, “хувьчлан авагч өмч хувьчлан авсан тухай гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй;” гэсэн үндэслэл байвал хувьчиллыг хууль бус гэж үзэж хүчингүй болгоно гэж, мөн зүйлд дээрх үндэслэлээр хувьчлалыг хүчингүйд тооцох шийдвэрийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана гэж тус тус зааснаас гадна Концессын тухай хуулийн 8.1.2-т “концессын гэрээний хугацаанд концессын зүйлийг хувьчлах шийдвэр гаргах”-ыг хориглохоор заасан.

Авлигатай тэмцэх газраас 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 32 дугаар “Мөрдөгчийн мэдэгдэл”-ийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах тодорхой арга хэмжээ авч ажиллахыг даалгасан бөгөөд “Мөрдөгчийн мэдэгдэл”-д Хөтөлийн Цемент Шохой ТӨХК /хуучнаар/-ийн хувьчлалыг хэрэгжүүлэхдээ Бейзмент ХХК-д давуу байдал бий болгон төрд их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдэгдсэн болохыг дурдаад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувьчлалыг хүчингүйд тооцох хэд хэдэн үндэслэл байгааг шалгаж тогтоосон тул Хөтөлийн Цемент Шохой ТӨХК /хуучнаар/-ийг төрийн өмчид буцаан авах шийдвэр гаргахыг даалгасан байна.

Иймд дээрх хуульд заасны дагуу “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 23-ны

өдрийн 124 дүгээр тогтоолоор "2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт"-аас "Хөтөлийн цемент шохой" ТӨХК-ийг хувьчлах заалтыг хасч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 108 дугаар тогтоолоор уг хувьчлалыг тодорхой үндэслэлээр хууль зөрчсөн гэж үзээд хүчингүйд тооцож зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна.

Түүнчлэн, өнөөгийн дэлхий дахинд үүсээд байгаа олон нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдал, хөрш, зэргэлдээ оронд бий болсон олон улсын хямралт нөхцөл байдлаас үзэхэд хилээр бараа, бүтээгдэхүүн тээвэрлэх, нэвтрүүлэх боломж бололцоогүй болох, дотоодод бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх, хомсдол үүсэх зэрэг сөрөг үр дагаврууд бий болдог байх тул барилга, зам, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарт өргөнөөр хэрэглэгддэг, гол нэр төрлийн материал болох цементийн үйлдвэрлэлийг төрийн оролцоо, дэмжлэгээр хангах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Ус, дулаан хангамж, инженерийн шугам сүлжээтэй, төвийн бүсийн цахилгаан, эрчим хүч, төмөр зам, авто замын нэгдсэн сүлжээнд холбогдсон, дэд бүтэц сайтай, сүүлийн үеийн дэвшилтэд техник технологи бүхий уг үйлдвэрээр дамжуулан бүтээгдэхүүний чанарыг сайжруулах болон цементийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангуулах, үнийн хөөрөгдлийг хязгаарлах, хянах боломж бүрдэж, төвийн болон зүүн бүсийн аймгууд Улаанбаатар хотоос цемент худалдан авч байгаа хөдөлгөөний ачааллыг бууруулах, хөдөө, орон нутгийн хэрэглээг шууд хангах системд шилжих боломжтой болно.

"Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ээс "4.17. "Хөтөлийн цемент шохой" төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах" гэсэн заалтыг хасах, өөрөөр хэлбэл, "Хөтөлийн цемент шохой" төрийн өмчит хувьцаат компанийг хувьчлахгүй байхаар уг Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар барилгын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох цементийн чанарыг сайжруулах, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангуулах, үнийн хөөрөгдлийг хязгаарлах, хянах боломж бүрдэх бөгөөд төвийн болон зүүн бүсийн аймгууд Улаанбаатар хотоос цемент худалдан авч байгаа хөдөлгөөний ачааллыг бууруулах, хөдөө, орон нутгийн хэрэглээг шууд хангах системд шилжих, бүтээн байгуулалтын ажлын өртөг, зардлыг бууруулах, орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байр бий болгох боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой гэж үзлээ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны ..... дугаар  
сарын ....-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн “4.17.”Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах” гэснийг хассугай.

ГАРЫН ҮСЭГ

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ 70 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТЫН  
4.17 ДАХЬ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ  
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн “4.17.”Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгээр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах.” гэсэн заалтад Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийлээ.

**Нэг.Үнэлгээ хийх болсон шалтгаан:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д Улсын Их Хурал “төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг *батлах, түүнд өөрчлөлт оруулах*” бүрэн эрхтэй гэж заасан.

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг баталсан бөгөөд түүний 4.17-д ““Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгээр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах”-аар заасан. Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 330, Төрийн өмчийн хорооны 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 608 дугаар тогтоолоор “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгээр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчилж, Төрийн өмчийн хорооны 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 617 дугаар тогтоолоор “Бейзмент” ХХК-д хувьцааны өмчлөгчийн эрхийг олгосон.

Авлигатай тэмцэх газраас 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 32 дугаар “Мөрдөгчийн мэдэгдэл”-ийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлсэн бөгөөд гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах тодорхой арга хэмжээ авч ажиллахыг даалгасан бөгөөд “Мөрдөгчийн мэдэгдэл”-д Хөтөлийн Цемент Шохой ТӨХК /хуучнаар/-ийн хувьчлалыг хэрэгжүүлэхдээ Бейзмент ХХК-д давуу байдал бий болгон төрд их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдэгдсэн болохыг дурдаад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувьчлалыг хүчингүйд тооцох хэд хэдэн үндэслэл байгааг шалгаж тогтоосон тул Хөтөлийн Цемент Шохой ТӨХК /хуучнаар/-ийг төрийн өмчид буцаан авах шийдвэр гаргахыг даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлд “хувьчлан авагч хөрөнгийн үнэ, хууль, гэрээнд заасан бусад төлбөрийг гэрээний хугацаанд төлөөгүй буюу төлбөрийг хууль бусаар хийсэн;”, “хувьчлан авагчид нь хуульд зааснаас илүү хөнгөлөлт, давуу эрх олгосон;”, “хувьчлан авагч өмч хувьчлан авсан тухай гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй;” гэсэн үндэслэл байвал

хувьчиллыг хууль бус гэж үзэж хүчингүй болгоно гэж, мөн зүйлд дээрх үндэслэлээр хувьчлалыг хүчингүйд тооцох шийдвэрийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана гэж тус тус заасан.

Иймд дээрх хуульд заасны дагуу “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт”-аас “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийг хувьчлах заалтыг хасч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 108 дугаар тогтоолоор уг хувьчлалыг тодорхой үндэслэлээр хууль зөрчсөн гэж үзээд хүчингүйд тооцож зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна.

Тухайлбал, ““Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ын “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-тай холбогдох 15 дахь хэсгийг хасч шийдвэрлэсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 108 дугаар тогтоолоор “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчилсан Төрийн өмчийн хорооны 2015 оны 608, 617 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгож, компанийн эрх, эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 110 дугаар тогтоолоор “Цемент шохой” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн холбогдох шийдвэрийг хүчингүй болгож, “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийг баталж, 119,452,690 ширхэг энгийн хувьцааг төрийн өмчид бүртгүүлэх шийдвэрийг гаргаад байна.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас мэдээлснээр “Бөйзмент” ХХК-нд 2010 онд олгосон 61.3 сая ам.долларын зээл, зээлийн хүүг хугацаандаа төлөөгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан боловч өр нь нийт 295 тэрбум төгрөгт хүрсэн байна.

“Бөйзмент” ХХК нь өмч хувьчлалд оролцохоос өмнө Худалдаа хөгжлийн банкнаас авсан 34 сая, хятадын CHIMEG компаниас авсан 21.5 сая ам.долларын зэрэг нийт 61.0 сая ам.долларын зээлийг Хөгжлийн банкнаас авсан зээлийн эх үүсвэрээр барагдуулсан болох нь баримтаар нотлогдсон байна.

Иймд Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолоор ““Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах”-аар тусгасан заалтын хэрэгжилтэд үнэлгээ хийх нь зүйтэй гэж үзсэн.

Түүнчлэн, өнөөгийн дэлхий дахинд үүсээд байгаа олон нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдал, хөрш, зэргэлдээ оронд бий болсон олон улсын хямралт нөхцөл байдлаас үзэхэд хилээр бараа, бүтээгдэхүүн тээвэрлэх, нэвтрүүлэх боломж бололцоогүй болох, дотоодод бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх, хомсдол үүсэх зэрэг сөрөг үр дагаврууд бий болдог байх тул барилга, зам, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарт өргөнөөр хэрэглэгддэг, гол нэр төрлийн материал болох цементийн үйлдвэрлэлийг төрийн оролцоо, дэмжлэгээр хангах зайлшгүй шаардлагатай байна.

Ус, дулаан хангамж, инженерийн шугам сүлжээтэй, төвийн бүсийн цахилгаан, эрчим хүч, төмөр зам, авто замын нэгдсэн сүлжээнд холбогдсон, дэд бүтэц сайтай, сүүлийн үеийн дэвшилтэд техник технологи бүхий уг үйлдвэрээр дамжуулан бүтээгдэхүүний чанарыг сайжруулах болон цементийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангуулах, үнийн хөөрөгдлийг хязгаарлах, хянах боломж бүрдэж, төвийн болон зүүн бүсийн аймгууд Улаанбаатар хотоос цемент худалдан авч байгаа хөдөлгөөний ачааллыг бууруулах, хөдөө, орон нутгийн хэрэглээг шууд хангах системд шилжих боломжтой болно.

#### **Хоёр. Үнэлгээний хүрээ**

Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн 4.17-д “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах”-аар заасан заалтын хүрээнд үнэлгээ хийгдэнэ.

#### **Гурав. Үнэлгээний шалгуур үзүүлэлт**

Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолын хавсралтын 4.17-д хийх үнэлгээг зорилгод хүрсэн түвшин гэсэн шалгуур үзүүлэлтээр хийхээр тогтов. Учир нь Улсын Их Хурлын тогтоол хэрэгжиж эхэлснээс хойш гарсан зардлыг тооцоолох боломжгүй тул зардлын өсөлт, бууралт болон зардал-үр өгөөжийн харьцаа гэсэн шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь үр дүнгүй юм. Түүнчлэн зорилгод хүрсэн түвшин гэсэн шалгуур үзүүлэлтээр тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэж байгаа асуудал, бэрхшээлийг тодорхойлох боломжтой гэж үзлээ.

#### **Дөрөв. Үнэлгээний харьцуулах хэлбэр**

Үнэлгээг хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш гарч байгаа үр дагавартай харьцуулж үзэхээр тогтов.

#### **Тав. Үнэлгээний дүгнэлт**

Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолын хавсралтын 4.17-д хийсэн үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, шалгуур үзүүлэлтийн томъёоллыг нэгдүгээр хүснэгтээр харуулав.

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох	Шалгуур үзүүлэлтийг томъёолох
<p>УИХ-ын 2015.07.03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн 4.17-д</p> <p><b>“Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах”</b></p>	<p>Зорилгод хүрсэн түвшин</p> <p>Үндсэн зорилго: Цаашид төрөөс дэмжиж явахад их хэмжээний зардал шаардагдах, санхүүгийн хувьд хүндрэлтэй болсон аж ахуйн нэгжийг хувийн өмчид шилжүүлж, төрд ирэх дарамт ачааллыг бууруулах, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангах</p>	<p>Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш гарч байгаа үр дагавартай харьцуулна<sup>1</sup></p> <p>Санхүүгийн үзүүлэлтийг харьцуулна.</p>	<p>Хуульд заасан арга, хэлбэрээр хувьчлалыг явуулсан уу?</p> <p>Хувьчлагдсан аж ахуйн нэгжийн өр төлбөрийн байдал хувьчлагдахаас өмнөх байдлаас хэрхэн өөрчлөгдсөн?</p>

“Хөтөлийн цемент шохой”-н үйлдвэр нь 1983 онд байгуулагдсан бөгөөд Засгийн газрын 2001 оны 35 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2001 оны 442 дугаар тогтоолоор хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн. Тус компани нь шохойн чулууны 2 орд газартай, үйлдвэрлэл тогтворжиж, бүтээгдэхүүний чанар баталгаажсан, дэд бүтэц сайтай, мэргэшсэн боловсон хүчин, туршлагатай ажиллах хүчний нөөцтэй байсан.

Улсын Их Хурлын 2010 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 86 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийн төхник, технологийг хуурай аргад шилжүүлэх нөхцөлтэйгөөр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

<sup>1</sup> -ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоол: 3.5.3.2.хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжээний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

Байвал зохих үзүүлэлтийг хууль тогтоомжил тодорхой заагаагүй бол хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал, тоо баримтыг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш бий болсон үеийн нөхцөл байдал, тоо баримттай харьцуулж болно

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Төрийн өмчийн хорооны даргын хамтарсан 2011 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн тушаалаар хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг томилж 2011 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр "... үндэсний хөрөнгө оруулагч "Бэйзмент" ХХК-ийн санал илүү үндэслэлтэй, итгэл үнэмшилтэй бөгөөд захиалагчийн ашиг сонирхолд нийцсэн байна гэж дүгнэсэн..." тул "Цемент шохой" ХК болон "Бэйзмент" ХХК-ийн хооронд байгуулсан "Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өргөтгөх" хөрөнгө оруулалтын гэрээг (10 жилийн хугацаатай) Төрийн өмчийн хороо 2011 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан байна.

"Бэйзмент" ХХК нь үндсэн гүйцэтгэгчээр БНХАУ-ын "China heavy industrial machinery export group pte"-тэй 2011 оны 06 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулсан ба өөрийн эх үүсвэр болон Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкны 39.5 сая долларын зээлийн санхүүжилтээр "Цемент шохой" ХК-ийн үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх ажиллагааг эхлүүлж 2014 онд дуусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 330, Төрийн өмчийн хорооны 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 608 дугаар тогтоолоор "Хөтөлийн цемент шохой" төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчилж, Төрийн өмчийн хорооны 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 617 дугаар тогтоолоор "Бэйзмент" ХХК-д хувьцааны өмчлөгчийн эрхийг олгосон байна.

**Хувьчлагдах үед:** "Хөтөлийн цемент шохой" төрийн өмчит хувьцаат компани нь 28,566,747,863 /хорин найман тэрбум таван зуун жаран зургаан сая долоон зуун дөчин долоон мянга найман зуун жаран гурав/ төгрөгийн богино хугацаат өр төлбөр, барилгын салбарыг дэмжих улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон 10,000,000,000 /арван тэрбум/ төгрөгийн зээл, 1,139,546,330 /нэг тэрбум нэг зуун гучин есөн сая таван зуун дөчин зургаан мянга гурван зуун гуч/ төгрөгийн банкны зээл, нийт 39,706,294,230 /гучин есөн тэрбум долоон зуун зургаан сая хоёр зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун гуч/ төгрөгийн өр төлбөртэй байсан байна. Мөн татвар, нийгмийн даатгалд өртэй, 2012, 2014 оны ногдол ашиг боох 1,045,109,400 /нэг тэрбум дөчин таван сая нэг зуун есөн мянга дөрвөн зуу/ төгрөгийг төрд төвлөрүүлээгүй байсан.

"Хөтөлийн цемент шохой" төрийн өмчит хувьцаат компанийг "Бэйзмент" ХХК-д хувьчилсан нөхцөл нь:

1. **Нийт 39,706,294,230** /гучин есөн тэрбум долоон зуун зургаан сая хоёр зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун гуч/ төгрөгийн өр төлбөрийг төлөх;
2. Татвар, нийгмийн даатгал, төрд төвлүүлээгүй ноогдол ашгийн өр төлбөр зэрэг бусдад төлөх өр төлбөрийг төлж барагдуулах нөхцөлтэйгөөр нийт 119 452 690 ширхэг хувьцааг худалдах доод үнийг **1,386,106,400** /нэг тэрбум гурван зуун наян зургаан сая нэг зуун зургаан мянга дөрвөн зуу/ төгрөгөөр тус компанийн 119 452 690 ширхэг хувьцааг хөрөнгө оруулагч "Бэйзмент" ХХК-д санал болгон худалдсан байна. **Өөрөөр хэлбэл нийт 41,100,000,000 /дөчин нэгэн тэрбум нэг зуун сая/ төгрөгөөр хувьчилсан.**

**"Хөтөлийн цемент шохой" /хуучин нэрээр/ ХК-ийн өнөөгийн нөхцөл байдал:**



Төрийн өмчийн хорооны 2011 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан “Цемент шохой” ХК болон “Бейзмент” ХХК-ийн хооронд байгуулсан “Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өргөтгөх хөрөнгө оруулалтын гэрээ”-ний дагуу 2 компанийн хооронд үүссэн 269.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн “Цемент шохой” /Хөтөлийн Цемент шохой ХК-ийн нэрийг өөрчилсөн/ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өрийг хувьцаагаар сольж, компанийн дүрмийг шинэчилсэн байна.

“Бейзмент” ХХК нь “Хөтөл” ХХК болон нэрээ өөрчилсөн бөгөөд “Цемент шохой” ХК-ийн 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор 2,870,840,893 ширхэг хувьцааг 100% эзэмшиж, холбогдох бүртгэлийг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 240 дүгээр тогтоолоор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлсэн. “Хөтөл” ХХК нь 2018 оны 9 сард “Цемент шохой” ХК дахь өөрийн эзэмшлийн хувьцаанаас 6,000,000 ширхэг хувьцааг “Гриндинг процесс” ХХК-нд худалдсан.

“Хөтөл” ХХК-ийн цор ганц хувьцаа эзэмшигч М.Бөх-Очирын 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01/2017 дугаартай шийдвэрээр компанийн дэд захирал Г.Ганзоригт итгэмжлэл олгосон боловч Иргэний хуулийн 67 дугаар зүйлийн 67.2.3-т заасны дагуу төлөөлүүлэгч М.Бөх-Очир 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр нас барснаар төлөөлөх эрх дуусгавар болсон байна.

“Хөтөлийн цемент шохой” ХК-ийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд Монгол банкны зээлийн мэдээллийн сангаас авсан лавлагаагаар зээлийн үлдэгдэлгүй байна.

#### **“Хөтөл” ХХК (Бейзмент)-ийн Хөгжлийн банкнаас авсан зээлийн тухай**

Монгол Улсын Хөгжлийн банкнаас мэдээлснээр “Бейзмент” ХХК-нд 2010 онд олгосон 61.3 сая ам.долларын зээл, зээлийн хүүг хугацаандаа төлөөгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан боловч өр нь нийт **295 тэрбум** төгрөгт хүрсэн бөгөөд цаашид ч нэмэгдэхээр байна.

“Бейзмент” ХХК нь өмч хувьчлалд оролцохоос өмнө Худалдаа хөгжлийн банкнаас авсан 34 сая, хятадын CHIMEG компаниас авсан 21.5 сая ам.долларын зэрэг нийт 61.0 сая ам.долларын зээлийг Хөгжлийн банкнаас авсан зээлийн эх үүсвэрээр барагдуулсан байна.

#### **Хувьчлалыг дараах үндэслэлээр хууль зөрчсөн гэж үзэхээр байна. Үүнд.**

1. Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн өмчийн хорооны шийдвэрүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувьчлалын аргыг дангаар буюу хослуулан хэрэглэхийг зөрчиж “Бейзмент” ХХК-д давуу байдал бий болгосон байна. Мөн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрд ногдох хувьцаа, ногдол хувийг чөлөөтэй, эсхүл багцалсан хэлбэрт оруулан биржээр, биржийн гадуур арилжиж худалдана

2. Хувьчлал явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хувьчлах хөрөнгийн талаар мэдээлэл хүргүүлэхээр заасныг хэрэгжүүлээгүй. Ялангуяа хувьцаатай холбоотой мэдээллийг хувьчлах үйл ажиллагаа эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө төр, засгийн газрын албан ёсны хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд сонордуулах заалт хэрэгжээгүй.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д зааснаар хувьчлан авагчид хуульд зааснаас илүү хөнгөлөлт, давуу эрх олгосон гэж үзэх үндэслэл байна. Учир нь ганцхан хөрөнгө оруулагчид шууд худалдах биш сонгон шалгаруулалт явуулж, ялсан этгээд нь хөрөнгө оруулагчид төлбөрийг буцаан төлөх боломж байсан. Хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгө, өр төлбөр нь “Бөйзмент” ХХК-д давуу тал болоод зогсохгүй төрийн өмчит компанийн үнэ цэнийг бууруулах үзүүлэлт болсон байна.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Төрийн өмчийн хорооны 608 дугаар тогтоолд заасны дагуу төлбөрийг хуваарийн дагуу хийгээгүй (гэрээнд өр төлбөрийг гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор төлөх, төлөөгүй тохиолдолд цуцлах заалтыг зөрчин өмчлөгчийн эрхийн гэрчилгээ олгосон, “Хөтөлийн цемент шохой” ХК-ийн өөрийнх нь үйл ажиллагааны борлуулалтаар нийт өр төлбөрийн 90%-ийг 2017 оны 03 дугаар сарын 24-нийг хүртэл хэсэгчлэн төлсөн)

-2012, 2014 оны ногдол ашгийн өр болох 1.04 тэрбум төгрөгийг 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дотор төлөх ёстой байсан боловч 500 сая төгрөгийг 2015.11.02-ны өдөр, 168.1 сая төгрөгийг 2015.12.07-ны өдөр, 365 сая төгрөгийг 2015.12.24-ний өдөр тус тус төлсөн;

-Татварын өрөнд 2016 онд 1.5 тэрбум төгрөгийг хугацаа хэтрүүлэн төлсөн бөгөөд 2016 оны жилийн эцсийн байдлаар 336 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Богино хугацаат өр төлбөр 2016.12.31-ний өдрийн байдлаар 2.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

5.Худалдах, худалдан авах гэрээнд Хөтөлийн Дулааны станцын бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагаа болон Хөтөл тосгоныг дулаанаар найдвартай хангах үүргийг хүлээж, Барилга, хот байгуулалтын яамтай гэрээ байгуулан ажиллах үүргийг хөрөнгө оруулагч талд үүрэг болгосон боловч ямар нэгэн гэрээ байгуулаагүй байна.

Иймд төрөөс дэмжиж явахад их хэмжээний зардал шаардагдах, санхүүгийн хувьд хүндрэлтэй болсон аж ахуйн нэгжийг хувийн өмчид шилжүүлж, төрд ирэх дарамт ачааллыг бууруулах, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хувьчлалыг явуулсан боловч 41,1 тэрбум төгрөгийн өртэй байсан аж ахуйн нэгжийг 295 тэрбум<sup>2</sup> төгрөгийн өртэйгөөр төрд хүлээн авч төлөвлөсөн зорилгоосоо ухарсан байна.

### **Зургаа. Үнэлгээний зөвлөмж**

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтын 4.17-д заасан “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах” гэсэн заалтыг өнөөгийн нөхцөл байдал, шаардлагад нийцүүлэх болон төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахтай холбогдох хуульд заасан арга хэлбэрийг зөрчиж, бусдад давуу эрх олгох байдлаар хувьчлах арга хэлбэрийг зааж өгсөн, улмаар хувьчлахаас өмнөх өр төлбөр хувьчилсны дараа төрд төлөх өр төлбөр нь 7 дахин нэмэгдсэн зөрчилтэй хувьчлал явагдсан үндэслэлээр хүчингүй болгосон тул

<sup>2</sup> Хөгжлийн банкны 2022.03.18-ны өдрийн 3/447 тоот албан бичиг

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ээс хасах нь зүйтэй байна.

----oOo----

## **“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн 4.17 дахь заалтад Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийлээ.

### **Нэг.Үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлт**

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хийх үр нөлөөний үнэлгээнд тогтоолын төсөл бүхэлдээ зорилгод хүрч чадах эсэхийг тогтоохын тулд зорилгод хүрэх байдал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дагаж мөрдөх боломжтой эсэхийг тогтоохын тулд практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авлаа.

### **Хоёр.Үнэлгээ хийх хэсэг**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” 70 дугаар тогтоолын хавсралтын 4.17-д “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах” гэснийг хассугай. гэсэн нэг заалттай бөгөөд уг заалтын хүрээнд үнэлгээ хийнэ.

### **Гурав.Шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг баталсан бөгөөд түүний 4.17-д “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах”-аар баталсан. Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 330, Төрийн өмчийн хорооны 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 608 дугаар тогтоолоор “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчилж, Төрийн өмчийн хорооны 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 617 дугаар тогтоолоор “Бэйзмент” ХХК-д хувьцааны өмчлөгчийн эрхийг олгосон.

Авлигатай тэмцэх газраас 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 32 дугаар “Мөрдөгчийн мэдэгдэл”-ийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлсэн бөгөөд гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах тодорхой арга хэмжээ авч ажиллахыг даалгасан байна.

Уг “Мөрдөгчийн мэдэгдэл”-д Хөтөлийн Цемент Шохой ТӨХК /хуучнаар/-ийн хувьчлалыг хэрэгжүүлэхдээ Бейзмент ХХК-д давуу байдал бий болгон төрд их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдэгдсэн болохыг дурдаад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувьчлалыг хүчингүйд тооцох хэд хэдэн үндэслэл байгааг шалгаж тогтоосон тул Хөтөлийн Цемент Шохой ТӨХК /хуучнаар/-ийг төрийн өмчид буцаан авах шийдвэр гаргахыг даалгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн ““Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай” 124 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ын “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-тай холбогдох 15 дахь хэсгийг хасч шийдвэрлэсэн.

Дээрх шийдвэрийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 108 дугаар тогтоолоор “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчилсан Төрийн өмчийн хорооны 2015 оны 608, 617 дугаар тогтоолыг хүчингүй болгож, компанийн эрх, эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 110 дугаар тогтоолоор “Цөмөнт шохой” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн холбогдох шийдвэрийг хүчингүй болгож, “Цөмөнт шохой” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийг баталж, 119,452,690 ширхэг энгийн хувьцааг төрийн өмчид бүртгүүлэх шийдвэрийг гаргаад байна.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас мэдээлснээр “Бейзмент” ХХК-нд 2010 онд олгосон 61.3 сая ам.долларын зээл, зээлийн хүүг хугацаандаа төлөөгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан боловч өр нь нийт 295 тэрбум төгрөгт хүрсэн байна.

“Бейзмент” ХХК нь өмч хувьчлалд оролцохоос өмнө Худалдаа хөгжлийн банкнаас авсан 34 сая, хятадын CHIMEG компаниас авсан 21.5 сая ам.долларын зэрэг нийт 61.0 сая ам.долларын зээлийг Хөгжлийн банкнаас авсан зээлийн эх үүсвэрээр барагдуулсан болох нь баримтаар нотлогдсон байна.

Иймд Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолоор ““Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах”-аар шийдвэрлэсэн нь дээрх сөрөг үр дагавруудыг бий болгосон учраас Улсын Их Хурал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д **“төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах”** гэж заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, уг заалтыг хассанаар зорилгодоо хүрч чадсан байна.

Мөн түүнчлэн тогтоолын төсөл нь практикт хэрэгжих боломжтой болох нь харагдаж байна.

### **Дөрөв. Зөвлөмж**

Улсын Их Хурлын тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн төсөл батлагдсан тохиолдолд зорилгодоо хүрэх байдал нь эерэг, тухайн зохицуулалтыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

Иймд тогтоолын төслийг хэвээр үлдээхийг зөвлөж байна.

**“ТӨРИЙН ӨМЧИЙГ 2015-2016 ОНД ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ 70 ДУГААР  
ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСНААР ХОЛБОГДОН  
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтын 4.17-д заасан “Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах” гэсэн заалтыг хасах тухай тогтоолын төсөл батлагдсанаар түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Энэхүү үнэлгээний зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцож, улмаар холбогдох ачааллыг багасгах, зардлыг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг тооцоход:

- 1.төрийн байгууллагын зардал;
- 2.хуулийн этгээдийн зардал;
- 3.иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус Улсын Их Хурлын тогтоолын төслөөр хувь хүн, төрийн байгууллага, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт үүрэг хүлээлгээгүй тул хуулийн хэрэгжилттэй холбоотой тэдгээрээс нэмэлт зардал шаардахгүй. Харин хувьчлалыг хүчингүй болгосноор “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компани болохтой холбоотой улсын бүртгэлд бүртгүүлэх 64000 төгрөгийн зардал гарч байна.

-----oOo-----

**“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСӨЛД ЯАМДААС ИРҮҮЛСЭН  
САНАЛЫН ТОВЪЁОГ**

№	Засгийн газрын гишүүдийн нэрс, санал ирүүлсэн огноо, дугаар	Ирүүлсэн санал	Тайлбар
1.	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар 2022.4.5 1/1881	“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцлаа. “Хөтөлийн цемент шохой” компанийг төр өөрийн өмчлөлд үлдээх тохиолдолд тогтоолын төслийн танилцуулгад дурдсан тус компанийн өр, төлбөрийн асуудлыг цаашид хэрхэн шийдвэрлэхийг анхаарах нь зүйтэй.	
2.	Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2022.4.7 08/1666	“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байна.	Дэмжсэн.
3.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа 2022.4.8 01/941	“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төсөл, танилцуулгатай танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй болно.	
4.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ 2022.4.12 01/1894	Засгийн газрын тогтоолын төсөлд санал авах тухай тус яамнаас ирүүлсэн саналын дагуу Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж санал авахаар ирүүлсэн байна. Хөтөлийн “Цемент шохой” ХК-ийн хувьчлалыг хүчингүй болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, холбогдох материалтай танилцлаа. Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байна.	Дэмжсэн.

	Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2022.4.7 1а/1294	“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцаад, тогтоолын төслийг дэмжиж байна.	Дэмжсэн.
5.	Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан 2022.4.8 01/502	“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй болно.	-
6.	Соёлын сайд Ч.Номин 2022.4.11 1/895	“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, холбогдох материалтай танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй болно.	-
7.	Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан 2022.4.12 01/281	“Тогтоолын хавсралтад өөрчлөл оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон холбогдох материалуудтай танилцлаа. Тогтоолын төслийг дэмжиж, тусгайлан өгөх саналгүй байна.	Дэмжсэн.
8.	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан 2022.4.12 1а/1658	“Тогтоолын хавсралтад өөрчлөл оруулах тухай” /”Хөтөл цемент шохой” ТӨХК/ Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй байна.	-
9.	Эрүүл мэндийн сайд С.Энхболд 2022.4.4	“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцлаа. Тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж, тусгайлан өгөх саналгүй байна.	Дэмжсэн.



	1а/1498		
10.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон 2022.4.5 01/883	“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, холбогдох материалтай танилцлаа. Тусгайлан өгөх саналгүй болно.	-

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэр	Албан тушаал	Утасны дугаар
1.	Ц.Нямдорж	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	
2.	С.Наранцогт	Эдийн засаг, хөгжлийн дэд сайд	99003447
3.	Б.Цэнгэл	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга	99114512
4.	Н.Мягмар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга	99109376
5.	Б.Тэлмүүн	Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга	99087638
6.	Ц.Баяр-Эрдэнэ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга	88117950
7.	Д.Дэлгэрмаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	88033540
8.	Н.Мандуул	Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал	99104200